

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +5
Шөнө -7

УЛС ТӨР

Ц.БАТБАЯР: Д.ОЮУНХОРОЛ САЙД НЭГ Ч ШОНХОР ХИЛЭЭР ГАРГАХ ЭРХГҮЙ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ЯЛГАВАРЛААГУЙ, ЯЛГАВАРЛАСАН

V нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Таналт байгаа оносонгүй

Ж.ОТТОНМЯГМАР

Эдийн засаг хямралтай хэцүү байгаа учир тэвчиж болох бүх зүйлийг хасч, танахаар болоод байгаа. Гэхдээ хасгах, танах ажил “Будаач будаач гэхээр сахлаа будав” гэгчийн үлгэр болоод байна. Хэдхэн хоногийн өмнө Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хувийн хэвшлийн МСУТ-үүдэд төсвөөс өгдөг хувьсах зардлыг хасч, тэтгэлэг болох 70 мянган төгрөгийг ч олгох боломжгүй гэдгээ албан бичгээр мэдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, их дээд сургууль, коллежид суралцаж оюутнууд 70 мянган төгрөгийн тэтгэлгээ үргэлжлүүлэн авах бол МСУТ-д суралцаж 40 мянга суралцагч энэ тэтгэлгийг авахгүй гэсэн үг.

Үргэлжлэл нь III нүүрт

“ТАХИР ДУТУУ” ХУУЛЬ БАТАЛЖ, ДҮР ҮЗҮҮЛЭВ ДЭЭ, ЭРХ БАРИГЧИД АА



Н.ПУНЦАГБОЛЦ

МАН засгийн эрхийг дангаараа барих болсноос хойш урагшаа биш ухарч алхсаар өнөөдрийг

хүргэлээ. Тэдний ухарсан алхмуудыг тоолбол барагдахгүй, хэлсэн хэлээгүй хүн бүхэн мэдэж байгаа. Энэ засгийн үед хийсэн хамгийн том ухралт бол Гэр

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг эргүүлэн татсан явдал байлаа. Уг асуудлаар олон хуульч, хүний эрхийн төлөө тэмцэгчид байр сууриа илэрхийлж,

халаглаж байна. Харин МАН-д үүнийг мэдрэх мэдрэмжтэй, сэтгэлтэй, чадвартай, мэдлэгтэй хуульч алга.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ҮР АШИГТАЙ, АЮУЛГҮЙ, ШУУРХАЙ ТЭЭВЭРЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

Н.ЗАЯА

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат ажлаа хүлээж аваад 100 хоног болж буйтай холбогдуулан зам, тээврийн салбарынхантай уулзаж, тэдний санал бодлыг сонсож байгаа билээ. Тэгвэл өчигдөр авто тээврийн салбарын нийт ажилтан, албан хаагчид, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй уулзалт хийж, цаашид зам, тээврийн салбарт баримтлах бодлого, шийдвэрлэх асуудлаа танилцууллаа. Автотээврийн салбар Монголын тээврийн бусад төрлүүдээс хамгийн ууган нь бөгөөд үйлчилгээг хэрэглэгчдэд хаалганаас хаалганд хүргэж өгдөг хамгийн өргөн хүрээг хамарсан салбар гэдгийг сайд уулзалтын эхэнд онцолсон. Бүх төрлийн тээвэрээр 2016 оны эхний хагас жилд 16.2 сая тонн ачаа тээвэрлэсний 43.8 хувь нь, давхардсан тоогоор 133.7 сая зорчигч тээвэрлэсний 98.8 хувийг нь автотээвэрээр үйлчлүүлсэн тооцоо

судалгаа бий. Автотээврийн салбарт өнөөгийн байдлаар 20 гаруй мянган хүн ажиллаж байгаа ажээ. Мөн энэ оны эхний хагас жилд 7.1 сая тонн ачаа, давхардсан тоогоор 132.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 0.6 сая тонн буюу 7.4 хувь, зорчигчид 23.7 сая хүн буюу 15.2 хувиар буурчээ. Түүнчлэн автотээврийн орлого 198.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар буурчээ. Харин манай улсад 2016 оны аравдугаар сарын 01-ний байдлаар 830039 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 482551 буюу 58.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэлтэй гэнэ. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн дунджаар 65 орчим хувь нь техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, авто машин өөрөө явагчийн албан татвараа төлжээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **15600**

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

PC mall. DELL ХААН БАНК

ЛИЗИНГИЙН ХҮҮ: ЖИЛИЙН 8% БОЛМОО

ЗӨВХӨН DELL БРЭНДИЙН НӨҮТБҮҮК

7575-3535 www.pcmall.mn /PCmallOfficial

ХААН банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2260.00	2278.00	ФУНТ	2768.00	2870.00
ЕВРО	2504.00	2575.00	РУБЛЬ	34.80	37.90
ИЕН	21.73	22.34	ЮАНЬ	336.00	340.80
			АМ.ДОЛЛАР	2260.00	2277.00
			ЕВРО	2504.00	2573.00
			РУБЛЬ	35.28	38.46
			ЮАНЬ	336.00	340.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

АСУУДЛЫН МӨРӨӨР



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ц.БАТБАЯР: Д.ОЮУНХОРОЛ САЙД НЭГ Ч ШОНХОР ХИЛЭЭР ГАРГАХ ЭРХГҮЙ

цагаан зээр 150-ийг агнах тогтоол гаргажээ. Үүний дагуу БОАЖ-ын сайд тусгай зөвшөөрлөөр агнах тушаалыг гаргасан аж.

...Түлэнхийн төв барихад зориулж, долоон сая ам.доллар, Хэнтий аймгийн нисэх онгоцны буудал барихад 12 сая ам.долларын хөрөнгийг шийдвэрлэсэн. Тиймээс хэн нэгэн өөрийн ашиг сонирхлын зөрчлөөс болж Ойрхи Дорнодын бүс нутгаас өндөр, дээд хэмжээний айлчлал хийж буй албан тушаалтнуудыг гүтгэж болохгүй” хэмээв...

Энэ үеэр шонхор шувууны асуудлаар Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын хэлтсийн дарга Д.Даваасамба сэтгүүлчдийн зарим асуултад хариуллаа.

“Бэлэглэлийн зориулалтаар гадаадад шонхор гаргах нууц тогтоол баталсан гэж ярьж байна. Энэ ямар учиртай юм бэ?”

“Зөвхөн гадны төрийн өндөр дээд албан тушаалтан айлчлал хийж буй Ойрхи Дорнодын бүс нутгийн өндөр албан тушаалтнуудад соёлын зориулалтаар шонхор шувууг гадаадад гаргадаг.

“Одоогоор хэчнээн ширхэг шонхор гадаадын орнуудад бэлэглэсэн бэ?”

“Нууц тогтоол учраас хэдэн ширхэг шонхор гаргасан нь нууцлалын зэрэглэлтэй байдаг.

“Яагаад нууц тогтоол гэж гаргасан юм бэ. Иргэд олон нийтэд нээлтэй, ил тод байх боломжгүй юм уу?”

“Энэ асуудлыг яамнаас бус Засгийн газрын хэрэг эрхлэх газраас тодруулах хэрэгтэй.

“Бэлэглэлийн журмаар шонхор гаргахад нөхөн төлбөр гэж авах уу?”

“Нэг шонхор бэлэглэхээр гаргахад нөхөн төлбөр болгож орон нутгийн төсөвт зургаан сая 400 мянган төгрөг, тэмдэгийн хураамж гурван сая 200 мянган төгрөг авдаг.

аргаль угалзын ангийн тухайд 2015 онд гаргасан Засгийн газрын тогтоолоор 2016 онд тусгай зориулалтаар угалз 60, тэх 70, халиун буга 30, саарал чоно 20, бор гөрөөс 10, зэрлэг гахай 10,

Ж.ОТГОН

Монголын мэргэжлийн анчдын холбооны тэргүүн Д.Хурцгэрэл нарынхүүмүүс энэ сарын 07-ны өдөр гадаадын анчид угалз, шонхор зэрэг ан амьтныг хууль бусаар агнаж байгаа тухай мэдээлсэн. Тэгвэл уг мэдээллийн дагуу БОАЖ-аас хэвлэлийнхэнд албан ёсны тайлбар мэдээлэл өглөө. Тус яамныхан Д.Хурцгэрэлийг өөрөө идлэг шонхор шувууг арилжаалах ашиг сонирхолтой болоод БОАЖ-ыг шангаажлан, сайд Д.Оюунхорол болоод бусад мэргэжилтнүүдийн нэр хүндэд үндэслэлгүйгээр халдаж буй тухай мэдэгдлээ. Улмаар БОАЖ-аас Д.Хурцгэрэлийг хуулийн байгууллагаар шалгуулж, нэр төрөө сэрээлгэхээр шүүхэд гомдол гаргажээ.

Энэхүү мэдэгдлийн талаар БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр “Иргэн Д.Хурцгэрэл шонхор шувууны экспортын асуудлаар ташаа мэдээлэл хийж, яам болон сайдын нэр төрд халдсан учир яамны зүгээс хууль хяналтын байгууллагад хандана. Учир нь БОАЖ-ын сайд нэг ч шонхор хилээр гаргах эрхгүй. Энэ асуудлыг Засгийн газрын тогтоолоор хэрэгжүүлдэг. 2013 онд Засгийн газраас Идлэг шонхор шувууг арилжааны зориулалтаар экспортод гаргахыг хориглох шийдвэр гарсан. Харин Ойрхи Дорнодын бүс нутгаас ирэх төрийн өндөр, дээд айлчлалын үеэр бэлэглэлийн журмаар олгодог. Энэ жил Засгийн газрын хуралдаанаар идлэг шонхор бэлэглэх талаар нууц тогтоол гарсан. Өөрөөр хэлбэл, төрийн

өндөр, дээд хэмжээний айлчлалаар ирж буй хүний аюулгүй байдлыг хангах үүднээс ирэх болон буцах өдөр, төлөөлөгчдийн тоо, хөтөлбөр зэрэг нь нууц байдаг. Үүнтэй холбоотой бэлэглэлийн шонхорын тоог ч нууцладаг. 2016 онд Ойрхи Дорнодын бүс нутгаас дөрвөн албан тушаалтан айлчлал хийсэн. Тус бүс нутгийн өндөр албан тушаалтан 50-150 хүнтэй, 23 онгоцоор ирдэг. Ирээд онгоцны буудлын төлбөр, зочид буудал, үйлчилгээ зэрэгт их хэмжээний орлого оруулдаг. Энэ оны 8-9 дүгээр сард л гэхэд 15 тэрбум төгрөгийн орлого орсон. Мөн зочид бэлэглэлээр өгч байгаа шонхор шувууг хилээр авч гарахын тулд сумын болон орон нутгийн төсөвт 10 тэрбум төгрөгийн татвар төлдөг. Нөгөө талаас сүүлийн 10 гаруй жилд

Ойрхи Дорнодын бүс нутгаас Монгол Улсад их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Тухайлбал, Тайширын усан цахилгаан станц барихад 13 сая ам.доллар, “Биологийн олон янз байдлыг судлах судалгааны төв” байгуулахад 3.4 сая ам.доллар, Хэнтий болон Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэгт 360 сая ам.долларын тоног төхөөрөмж олгосон зэргийг дурьдаж болох юм. Түүнчлэн Түлэнхийн төв барихад зориулж, долоон сая ам.доллар, Хэнтий аймгийн нисэх онгоцны буудал барихад 12 сая ам.долларын хөрөнгийг шийдвэрлэсэн. Тиймээс хэн нэгэн өөрийн ашиг сонирхлын зөрчлөөс болж Ойрхи Дорнодын бүс нутгаас өндөр, дээд хэмжээний айлчлал хийж буй албан тушаалтнуудыг гүтгэж болохгүй” хэмээв. Харин

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Намын бүлгүүд хуралдсангүй

УИХ дахь намын бүлгүүд даваа гараг бүр хуралдаж, тухайн долоо хоногийн асуудлаа авч хэлэлцдэг. Харин энэ удаад АН, МАН-ын бүлэг хуралдсангүй. АН-ын

бүлгийн гишүүд орон нутгийн сонгууль дөхсөнтэй холбоотой хөдөө ажиллаж байгаа тул бүлэг хуралдаагүй аж. Харин МАН-ын бүлэг хурал зарласан боловч ирц бүрдээгүй гэх

шалтгаанаар хойшлогдож байгаад хурлаа цуцалсан юм. Хурал цуцлагдсан шалтгаан нь зарим гишүүд сонгуульд ажлаар хөдөө, орон нутагт явж байгаатай холбоотой юм байна.

Улаанбаатар хот гамшгийг даван туулах чадавхитай хот болох нь



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон Дархан, Эрдэнэт хот нь НУБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын “Аюулгүй, гамшгийг даван туулах чадавхтай хотыг бий болгох нь” уриалгад нэгдлээ. Энэ ёслолд Шадар сайд У.Хүрэлсүх, Монгол Улс дахь НУБ-ын суурин зохицуулагч, НУБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн суурин төлөөлөгч Биата Транкман болон албаны бусад хүн оролцов. Одоогийн байдлаар таван тивийн нийт 3368 хот энэхүү уриалгад нэгдэн орсон байдаг байна.

НУБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын гамшгийн эрсдэлийг бууруулах тусгай төлөөлөгч Маргарета Волстром Монгол Улсын

Шадар сайд У.Хүрэлсүхийн урилгаар өнгөрсөн оны тавдугаар сард айлчлал хийх үеэр уг уриалгад Улаанбаатар хотыг нэгдэн орох санаачилгыг анх тавьж байсныг өргөжүүлэн Шадар сайдын санаачилгаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гурван хот уг уриалгад нэгдэн орж, гэрчилгээг хүлээж авлаа. Уг уриалга нь гамшгийг тэмцэх чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжин, орон нутгийн төвшин дэх гамшгийн эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх замаар хот суурин газрын тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа юм. Сүүлийн хоёр жилийн хугацаанд нийслэл хотод 6600 гаруй, Дархан, Орхон аймагт 800 гаруй гаруй

аюулт үзэгдэл, осол тохиолдсон нь бусад аймагтай харьцуулбал нийслэл хот 30 дахин, Дархан, Орхон аймаг хоёрдахинх гэсэн үг юм. Гамшгийн аюул, ослоос шалтгаалан 373 хүн нас барж, 328 хүн бэртэж гэмтсэнээс 70 хувь нь Улаанбаатар хотод, 10 орчим хувь нь Дархан, Орхон аймагт тохиолдсон байна. Иймд нийт хүн амын 80 гаруй хувь нь хот, суурин газар амьдардаг манай улсын хувьд хотуудын гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, аливаа гамшгийг даван туулах чадавхтай болгох, ард иргэдийн аюулд өртөх эмзэг байдлыг багасгах нь төв, орон нутгийн удирдлага, төр засгийн анхаарах чухал асуудлын нэг болоод байгаа юм.

Ерөнхийлөгч ДАШТ-д оролцох шатарчдыг хүлээн авч уулзав

Ж.МЯГМАР

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ДАШТ-д оролцох өсвөрийн шатарчид болон Монголын Шатрын холбооны удирдлагуудыг хүлээн авч уулзлаа. Уулзалтад МШХ-ны Гүйцэтгэх захирал Б.Наранбаатар, ДШХ-ны Монгол дахь төлөөлөгч, МШХ-ны Дэд Ерөнхийлөгч Ц.Цогбаяр, МШХ-ны Дэд Ерөнхийлөгч Д.Баярболд, Өсвөрийн шатарчдын зөвлөлийн дарга Г.Даваахүү нар өсвөрийн шатарчидтайгаа оролцлоо.

Гүрж Улсын Батуми хотноо энэ аравдугаар сарын 18-31-ний хооронд зохион байгуулагдах 8, 10, 12 насны өсвөрийн шатарчдын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн шилдэг өсвөрийн 19 шатарчид оролцох юм. Уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч өсвөрийн шатарчдын гаргаж буй амжилтыг үнэлж, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох өсвөрийн шатарчдад амжилт хүсээд, цаашид шатрын спортыг дэмжихээ илэрхийллээ. Гүржид болох ДАШТ-д Өсвөрийн шатарчдын дэлхийн аварга, сурагчдын дэлхийн аваргын мөнгөн медаль, Ази тивийн аварга Д.Мөнхзул, Өсвөрийн шатарчдын дэлхийн аваргын мөнгөн медаль, сурагчдын дэлхийн аварга, Ази тивийн аварга Е.Төгсгөмөр, Өсвөрийн шатарчдын дэлхийн аваргын мөнгөн медаль, Ази тивийн аварга Б.Мөнгөнзул, Сурагчдын дэлхийн аваргын мөнгөн медаль, Ази тивийн аварга Г.Амартүвшин нарын зэрг өсвөрийн 19 тамирчин оролцохоор бэлтгэлээ базаагаад байна.

Ж.Эрдэнэбат Орхон, Булган, Хөвсгөл аймагт ажиллалаа

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ сарын 6-8-нд Орхон, Булган, Хөвсгөл аймагт ажиллалаа. Тэрбээр Ерөнхий сайдаар томилогдсоноос хойшхи хугацаандаа долоон аймагт томилолтоор ажиллаад байгаа юм. Эдгээр аймгийн иргэдтэй уулзалт хийх үеэрээ Ерөнхий сайд, УИХ-ын ээлжит бус хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө батлуулсан. Энэ хөтөлбөрт МАН-аас УИХ-ын сонгуульд дөвшүүлж оролцсон мөрийн хөтөлбөрийг 100 хувь тусгасан. Засгийн газраас ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглалын олон зорилт туссан, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан, УИХ-д өргөн барихад бэлтгэж байгааг дуулав. Түүнчлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөрүүд болох Оюутолгойн далд уурхай, Тавантолгойн төсөл, Тавантолгойн цахилгаан станц, Дулааны III цахилгаан станцыг өргөтгөх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, эрчимжүүлэхээр ажиллаж байгааг онцолж байлаа.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ЭДИЙН ЗАСАГ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ҮР АШИГТАЙ, АЮУЛГҮЙ, ШУУРХАЙ ТЭЭВЭРЛЭЛТИЙН
НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат уулзалтын үеэр автотээврийн салбарт ойрын хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар танилцуулсан юм. Тэрбээр “Зах зээлийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж үйлдвэрлэл, худалдаа хил хязгааргүй өргөжиж байгаа энэ үед зам, тээврийн салбарын эрхэм зорилгыг “Эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээг үзүүлэх явдал мөн” гэж тодорхойлсон” хэмээн хэллээ.

Сайд Д.Ганбат саяхан орон нутагтаг ажиллаж, Тавантолгой-Гашуунсухайт хилийн боомт хүртэлх нүүрсний тээвэрлэлттэй газар дээр нь танилцаад ирсэн талаараа нийт тээвэрчиддээ танилцууллаа. Ямар нэгэн бодлого, зохион байгуулалтгүй тээвэрлэлтээс болж хүний амь нас эрсдэж, осол гарч, жолооч нар эрүүл мэндээрээ хохирч байгаа дүр зурагтай байгаа тул энэ тал дээр нарийн зохион байгуулалт шаардлагатай байгааг ярьж байв. Мөн тээвэр зуучийн 200 гаруй компани Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ихэнх нь стандартын шаардлага хангахгүй байгааг шүүмжиллээ. Тиймээс ачаа тээврийн үйлчилгээнд тээврийн зохистой бодлого, зохицуулалтын зөв механизмыг бүрдүүлэх, тээвэрлэлтийн үйлчилгээнд цахим хяналт, бүртгэлийн систем нэвтрүүлэх, жолоочийн ажил амралтын дэглэм, сахилга хариуцлагыг дээшлүүлэх тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, шуурхай тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана гэв.



Тээвэр логистикийн үйлчилгээг хөгжүүлэх замаар дотоодын ачаа тээврийн үйлчилгээг зохицуулах, төмөр замын тээвэр, агаарын тээврийн үйлчилгээтэй холбогдон ажиллах, аливаа ачааг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийн горимын дагуу тээвэрлэлт гүйцэтгэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байгааг ч хэлж байв.

Монгол Улс Засгийн газраас өнөөдрийн байдлаар есөн улсын Засгийн газартай улс хоорондын болон дамжин өнгөрөх автотээврийн харилцааны тухай хэлэлцээр байгуулж, олон улсын таван конвенц, хоёр хэлэлцээрт нэгдэн оржээ.

Монгол - Орос - Хятад гурван

улсын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд “Азийн авто замын сүлжээгээр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг энэ оны арванхоёрдугаар сард байгуулах бөгөөд тус ажлын хүрээнд Монгол, Орос, Хятад гурван улсын Тээврийн яамдын дэмжлэг дор Тяньжин боомт-Улаанбаатар-Улаан-Үд хотын чиглэлд туршилтын ачаа тээвэрлэлтийг өнгөрсөн наймдугаар сард зохион байгуулсан юм.

Сайд уулзалтын үеэр зам, тээврийн салбарт баримтлах бодлогуудаа танилцуулах үеэр тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын үйл ажиллагаа

хангалтгүй байгааг хэлж байв. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг 2017 онд хэрэгжүүлэх бөгөөд энэхүү арга хэмжээгээр тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой зөрчлүүдийг арилгах, ашиглагдахгүй болсон тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. Үүний тулд тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээний үйл ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах тул нийт тээвэрчид үүнд идэвх санаачлагатай ажиллахыг уриалав.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд техникийн хяналтын үзлэгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг баталгаажуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Ингэхдээ шинэ санал, санаачлага гаргаж буй тээвэрчид, авто тээврийн ажилтан, албан хаагчдыг дэмжиж ажиллахаа сайд илэрхийлэв.

Мөн Зам, тээврийн хөгжлийн яамнаас тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хэрэглэгчдийн үйл ажиллагаа, төрөл, хүчин чадлаас хамааруулан тухайн авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох, засвар үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, засвар үйлчилгээнд баталгаа гаргах зэрэг тогтолцоог хөгжүүлэхээр төлөвлөжээ.

Түүнчлэн тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратегийг шинэчлэх, хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөв байгаа аж.

МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд сурталчилна

Нийслэлийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын даргын энэ сарын 05-ны өдрийн тушаалаар Нийгмийн даатгалын бодлого, хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчлах ажлыг эхлүүллээ. “Засгийн газрын 100 хоног” арга хэмжээг дүүргүүдийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд зохион байгуулах бөгөөд нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааг иргэдэд ойртуулж, сургалт, сурталчилгаа явуулан, зөвлөгөө өгч ажиллах юм. Өнөөдөр томоохон зах, худалдааны төвүүдэд дүүргийн байцаагч нар ажиллаж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдад хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийн талаархи мэдээлэл өгнө.

Мөн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүдтэй хамтран малчид, хөдөлмөр эрхлэгчид, бүртгэлтэй ажилгүй иргэдэд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын ач холбогдлын талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг дүүрэг бүрт хувиарийн зохион байгуулна. Дүүргүүдийн алслагдсан хороодын иргэд болон 1000 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын үйлчилгээг ойртуулж, зөвлөгөө, мэдээлэл хүргэх юм. Түүнчлэн иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа авах цахим үйлчилгээ, гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэд нийгмийн даатгалын шимтгэлээ онлайнаар төлөх боломж, мобайл банкны үйлчилгээний талаар иргэд даатгуулагч нарт мэдээ мэдээллийг шуурхай хүргэх зэрэг олон ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхээр боллоо.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 АХИЙ ЖИЛЭЭ

Манай сонины
IV улирлын
нэмэлт захиалга
үргэлжилж
байна

Улиралд

44

дугаар

Захиалгын үнэ
15600



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025



“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН
ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.



Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоостатгалгаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд

сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлэнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО
Холбоо барих утас: 99094864

ОНЦЛОХ ХУУДАС

АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙГ ЯЛГАВАРЛААГҮЙ, ЯЛГАВАРЛАСАН

Эсрэг тэсрэг байр суурь

Ж.Мөнхбат:
Чухал гэсэн салбаруудаа татварын хөнгөлөлтөд оруулъя



/Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга/

-Засгийн газар байгуулагдсаны дараа 10-аад салбарын хувийн хэвшлийнхэнтэй уулзсан. Жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй уулзахад “Монголд ажлын байр бий болгож байгаа гол дөрвөн салбар бий” гэж хэлж байсан. Тиймээс хөдөө аж ахуй, барилга, хувцас, нэхмэл, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг хөнгөлөхөөр шийдсэн юм. Энэ бол Засгийн газар гэхээсээ илүү хувийн хэвшлийнхний өөрсдийнх нь оруулж ирсэн санал. Бүх хувийн хэвшлийн үүнд хамруулна гэх юм бол бараг 30-аад тэрбум төгрөгийн орлогын асуудал үүснэ. Энэ орлогыг хаанаас олох вэ гэдэг асуудал үүснэ. Хоёрдугаарт, эдийн засаг хүндрэлтэй байгаа үед хамгийн чухал гэсэн салбаруудаа хамруулъя гэдэг байдлаар оруулж ирсэн юм.

...Жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй уулзахад “Монголд ажлын байр бий болгож байгаа гол дөрвөн салбар бий” гэж хэлж байсан. Тиймээс хөдөө аж ахуй, барилга, хувцас, нэхмэл, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг хөнгөлөхөөр шийдсэн юм...

...Тодорхой хугацаанд татварыг нь тэглээд аж ахуйн нэгжүүдээ дэмжвэл дээр юм биш үү. Уг нь 90 хувийг нь хасах бус буцааж олгох нь аж ахуйн нэгжүүдийг бүртгэлжүүлэх, хариуцлагажуулах чухал бодлого байсан юм. Гэвч АН-ын бодлого байсан болохоор хийж болдоггүй юм шиг байна...



С.Эрдэнэ:
Нэг хувийг үлдээсэн ч яалаа, больсон ч яалаа

/УИХ дахь АН-ын бүлгийн дарга/

-Эдийн засгийн хүндрэлтэй үед аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бууруулах нь чухал. Харин аж ахуйн нэгжүүдийг ялгаварлан гадурхаж байгаа юм шиг явуулж байгаа үйл ажиллагааных нь чиглэлээр ангилах нь зохимжгүй гэж үзэж байна. Хоёрын хооронд 90 хувь бууруулж нэг хувь болгоно гэж байхаар тэглэчихвэл яасан юм бэ. Тодорхой хугацаанд татварыг нь тэглээд аж ахуйн нэгжүүдээ дэмжвэл дээр юм биш үү. Уг нь 90 хувийг нь хасах бус буцааж олгох нь аж ахуйн нэгжүүдийг бүртгэлжүүлэх, хариуцлагажуулах чухал бодлого байсан юм. Гэвч АН-ын бодлого байсан болохоор хийж болдоггүй юм шиг байна. Ер нь өмнөх Засгийн газрынхаа сайн ажил болгоныг л үгүйсгэж байна. Энэ нь сайн үр дүн өгөх ч юм уу, үгүй ч юм уу. Аж ахуйн нэгжүүдийг хийж байгаа ажлаар нь ялгаварлаж, татварынх нь 90 хувийг хөнгөлнө гэж хоёрын хооронд ажил хийж байхаар тэглэчихвэл яасан юм бэ. Бизнес хийхэд үүсдэг нэг ч гэсэн дарамтыг нь арилгая. 90 хувийг нь хөнгөлж болж байгаа юм чинь шууд тэглэчихэж болно шүү дээ. Нэг хувийг нь үлдээсэн ч яалаа, больсон ч яалаа. Эдийн засгийн боломж байгаа юм бол түүнийгээ төгс ашиглаад явъя л даа.

С.Бямбацогт: Энэ бол өнөөдрийн нөхцөлд яг таарсан хувилбар



/Хууль зүйн сайд/

-2014 онд Я.Содбаатар нарын гишүүд 1.5 тэрбумаас доош орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг нэг хувь болгох хуулийг санаачилсан. Харамсалтай нь, АН-ынхан эрх барьж байх үедээ бидний санаачилсан хуулийг хэлэлцэхгүй байсаар өдий хүрсэн. Гэхдээ МАН мөрийн хөтөлбөртөө энэ асуудлыг тусгасан. Тиймээс Засгийн газар энэ асуудлыг оруулж ирж байна. Өмнө нь АН-ынхан 10 хувийн татвар авчихаад 90 хувийг нь буцааж олгоно гэсэн хууль санаачилж байсан. Татвар авчихаад буцаагаад өгөхийн тулд хүнд суртал гаргана. Бид бол хөдөө аж ахуй, барилга, хувцас нэхмэл, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа, импортыг орлож, экспортыг дэмжиж ажиллаж байгаа жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдээс нэг хувийн татвар авах хуулийг оруулж ирж байгаа юм. Энэ бол өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдалд хамгийн зохимжтой хувилбар. Үүнд ямар нэг ялгаварлал байхгүй. Энд бас бодлого байх ёстой. Гадаад худалдаа, импортыг дэмжсэн компаниудын татварыг нэг хувь болгогчивол эргээд валютын нөөц гэх мэт асуудалд нөлөөлнө. Бодлогын хүрээнд нийтдээ 4700 орчим аж ахуйн нэгж энэ хуульд хамрагдана.

Сэтгүүлчийн дүгнэлт

ДӨРӨВХӨН САЛБАРЫГ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТӨӨР “ШАГНАХ”-ЫН УЧИР ЮУ ВЭ

Н.ПУНЦАГБОЛД

МАН дахиад л мөрийн хөтөлбөрөөсөө ухарсан, амлалтаасаа буцсан ажил хийлээ. Уг нь МАН сонгуулийн мөрийн хөтөлбөрт “1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг нэг хувь болгоно” гэж заасан. Үүнийг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дарга нар, бизнес эрхлэгчид 1.5 тэрбумаас доош орлоготой бүхний л байгууллага гээд ойлгочихсон. Бүр МАН-ын гишүүн нь хүртэл тэгж ойлгож байсан талаар ярьсан. Гэтэл яг ачир дээрээ амласнаасаа буцаж, ердөө л дөрөвхөн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 4700 орчим аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлтөд хамруулахаар болж байх шиг байна. Яах вэ, сөрөг хүчнийхэн эсэргүүцээд, бизнес эрхлэгчид хэлээд ирэхээр иргэдэд таалагдахаас өөрийг хүсдэггүй энэ намынхан эргэж харж магадгүй л юм.

Ер нь бол хоёр намынхан тодорхой хэдхэн асуудал дээр маргаад байгаа. АН-ынхан болохоор 10 хувийн татварыг нь аваад, дараа нь 1.5 тэрбумаас доош орлоготой аж ахуйн нэгжүүдэд 90 хувийг нь буцаагаад өгөх хуулийн төсөл санаачилж байж. Харин МАН-ынхан болохоор шууд л 90 хувийг нь хөнгөлөөд, нэг хувийн татвар авахаар хууль санаачлаад байгаа юм. АН-ынхан 10 хувийн татвар авчихаад, буцаагаад 90 хувийг нь өгөх нь аж ахуйн нэгжүүдээ бүртгэлжүүлэх, хариуцлагажуулах чухал тогтоолоо байсан гээд өөрсдийгөө өмөөрөөд байна. Харин МАН-ынхан болохоор буцаан олголт нэрээр хүнд суртал гаргаж, шан харамж авах гэсэн арга гэж дайраад байгаа. Уг нь бол буцаан олгоно энэ тэр гэж заваарч байхаар шууд л хөнгөлчихсэн нь дээр. Харин нэг хувь болгож хөнгөлөх, ердөө дөрөвхөн салбарт энэ хөнгөлөлтөө үзүүлж байгаа нь л жаахан гажиг байна. Ердөө л дөрвөн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 4700-хан аж ахуйн нэгжид хөнгөлөлт үзүүлэх гэж байгаа юм бол шууд л тэглэчихээч дээ. Хоёрын хооронд, гурвын дунд нэг хувийн татвар аваад ч яадаг юм.

За тэр ах дүү, амраг садныхаа бизнесийг дэмжлээ гээд л хэрүүл уруул хийгээд байгаа. Яах вэ, дунд нь хэдэн хүний компани, бизнес багтаж л байгаа байх. Гэхдээ бор зүрхээрээ бизнес хийгээд, хэдэн хүнийг ажлын байраар хангаад явж байгаа хүн зөндөө л байгаа шүү дээ. Тэднийгээ дэмжих хэрэгтэй. Нөгөөталаар Ө.Энхтүвшин гишүүний хэлээд байгаа шиг хамрах хүрээг нь жаахан тэлээд өгвөл яасан юм. За тэр гаднаас бараа бүтээгдэхүүн оруулж ирдэг аж ахуйн нэгжүүдийг дэмжихэд хэцүү л байгаа биз. Сөрөг үр дагавартай л байх. Хууль зүйн сайд С.Бямбацогтын ярьсанд бас үнэний ор байгаа. Гэхдээ үйлчилгээний салбарыг багтаагаагүй нь гайхалтай байна. Мөн өөр олон л салбарыг энэ татварын хөнгөлөлтөд багтааж болмоор санагдах юм. Монголоор дүүрэн байгаа аж ахуйн нэгжүүд бүгд л гаднаас элдэв бараа зөөж оруулж ирээгүй шүү дээ. Тийм болохоор хамрах хүрээг нь жаахан тэлээд, хөнгөлөлтөө заваал 90 гэхгүй 50-60 болгосон ч яах вэ дээ. Заавал мөрийн хөтөлбөрт нэг хувь гэж тусгасан, түүнийгээ л биелүүлнэ гэж өрөөл татанхай хууль гаргаж, цөөхөн хэдэн аж ахуйн нэгжийг дэмжих хэрэг юу байгаа юм.

Түүний оронд олуулаа идсэн огогоно турахгүйн жишгээр олон аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлтөд хамруулаад, 3-4 хувийн татвар авчихдаг болсон ч болно. Тэглээ гээд нэг хувь болгосонгүй гэж далчигнах үйлдвэрлэл эрхлэгч гарч ирэхгүй л болов уу. Зөвхөн дөрөвхөн салбарын хэдэн аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлтөөр “шагнах” гэж буйн цаана юу байна. Мөрийн хөтөлбөрөө биелүүлсэн болж харагдах гэсэн оролдлого уу. Эсвэл сөрөг хүчний гишүүдийн ярьж байгаа шиг зөвхөн ах дүү, амраг садныхаа бизнесийг л дэмжих гээд байна уу.

Ө.Энхтүвшин: Үйлчилгээний салбарыг татварын хөнгөлөлтөд оруулаагүй байна



/УИХ-ын гишүүн/

-Манай намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт “1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой аж ахуйн нэгжүүдийн татварыг нэг хувь болгоно” гэж заасан. Иргэд бол 1.5 тэрбумаас доош орлоготой бүх аж ахуйн нэгж хамаарах юм байна гэж ойлгосон. Бид ч ингэж ойлгоод ярсан. Гэтэл одоо цөөхөн аж ахуйн нэгжийг хамруулах болчихоод байна. Тиймээс хэлэлцүүлгийн үед ямар салбаруудыг нэмж хамруулж болохыг ярилцах нь зөв байх. Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбаруудыг хамааруулсан гэж байна. Гэтэл дөрөвхөн салбарыг хамруулаад импортыг орлоно гэж байхгүй л дээ. Саяхан телевизээр гадаадаас авдаг цахилгааны утсыг 100 хувь дотооддоо үйлдвэрлэдэг болж байгаа гээд ярьж байсан. Гэтэл энэ нь татварын хөнгөлөлтөд орохгүй нь. Мөн “Эрдэнэт”-ийн ган бөмбөлгийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон гэсэн. Тэр ч үүнд хамаарахгүй нь. Ажлын байр бий болгож байгааг нь бас харах хэрэгтэй. Үйлчилгээний салбарыг оруулаагүй байна. Гэтэл худалдаа, үйлчилгээний салбар ажлын байрыг ихээр бий болгодог. 300-400 хүн ажиллуулдаг худалдаа, үйлчилгээний салбар байвал яах вэ. Хамгийн гол нь хямралын үед ажлын байрыг хадгалж үлдэх нь төрийн бодлогын асуудал шүү дээ. Ажлын хэсгээ гаргаж ажиллуулаад намынхаа мөрийн хөтөлбөрт ойртуулахгүй бол бидний хийж байгаа ажил буруу талаасаа ойлгогдох гээд байх юм.

ДЭЛХИЙ

ЦАГААН ОРДНЫ ТӨЛӨӨХ БОХИР МЭТГЭЛЦЭЭН



Б.ДАВААХҮҮ

Дэлхийн нэгэн хүчирхэг гүрэн болох АНУ-ын дараагийн Ерөнхийлөгч ирэх арваннэгдүгээр сарын 8-нд тодорно. Энэ сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нэр дэвшиж байгаа. Тэд хоёулаа эрс тэс туршлагатай. Хиллари Клинтоны хувьд улс төрийн арвин туршлагатай бол Доналд Трамп бизнесийн хүрээнд туршлага хуримтлуулж чадсан нэгэн юм. Тэдний анхны мэтгэлцээн есдүгээр сарын 26-нд болсон бол хоёр дахь мэтгэлцээн нь орон нутгийн цагаар өнгөрөгч ням гарагт боллоо. Гэхдээ өнгөрсөн удаагийн мэтгэлцээнээс энэ удаагийнх илүү “бохир” болсон гэдгийг эх сурвалжууд онцолж байгаа юм. АНУ-ын Миссури мужийн Сент Луйс болсон хоёр дахь удаагийн халт мэтгэлцээн эхнээсээ дуусах хүртлээ нэг нэгдүгээр сарын амьдрал руу дайрч давшилсан довтолгооноор дүүрч, зарим үед ердийн мэтгэлцээний хэм хэмжээнээс хальж байжээ. Халт мэтгэлцээнээр нэр дэвшигчид өөрийн бодлогыг өрсөлдөгчтэйгөө харьцуулан жишиж, улс

төр ярьдаг бол энэ удаа хувь хүн рүү нь халдаж, хэн бэ гэдгийг нь харуулах гэсэн доромж утгатай мэдэгдлүүд зонхилж байв. Хэдхэн хоногийн өмнө буюу өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампын эмэгтэйчүүдийг гутамшигтай муухайгаар хэлж буй бичлэг цацагдаж, нийгэмд том дуулиан тарьсан. Үүнтэй холбогдуулан намын нөхөд нь ч түүнд урам хутгарч буйгаа мэдэгдэн нүүр буруулж эхэлсэн билээ. Тэгвэл энэ байдлыг мэтгэлцээнээр дамжуулан дахин өөрийн талд эргүүлэхийн тулд Доналд Трамп Хиллари Клинтоны нөхөр АНУ-ын экс Ерөнхийлөгч Билл Клинтоны хормойн явдлыг дурьдана гэдгээ өмнө нь мэдэгдэж байв. Үүнээс гадна халт мэтгэлцээн болохоос ердөө 90 минутын өмнө Билл Клинтонд хүчирхийлсэн гэх эмэгтэйчүүдийн хамтаар хэвлэлийн хурал зарлаж дуулиан тарьсан юм.

Тиймээс ч халт мэтгэлцээн олон хүний анхаарлыг татаад амжсан. Таамагласаны дагуу мэтгэлцээний эхэнд хэвлэлээр цацагдсан Доналд Трампын бичлэгийн талаар сэтгүүлч Андерсон Купер асуухад тэрбээр хэлсэн зүйлээрээ бахархаггүй байгаагаа хэлж, уучлал хүссэн ч, энэ бол

зүгээр л цоожтой хаалганы цаана ярьдаг яриа гэснээрээ өөрийгөө зөвтгөж орхилоо. Мөн олны анхаарлын төвөөс өөрийгөө холдуулахын тулд өмнө хэлж байсанчлан, Билл Клинтоны хормойн явдлыг сөхөж эхэлсэн юм. Тэрбээр “Билл Клинтоны хэрэг л хамгийн аймшигтай нь. Би зүгээр л үг хэлсэн. Харин тэр үйлдлээрээ эмэгтэйчүүдтэй зүй бус харьцсан. АНУ-ын улс төрийн түүхэнд түүнээс өөр эмэгтэйчүүдтэй зүй бусаар харьцсан улстөрч байхгүй” хэмээн хатуухан хэлж, өрсөлдөгч рүүгээ давшилсан бол үүний харинд Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон Доналд Трампын журамгүй үг хэллэг өөрийг нь ямар хүн бэ гэдгийг тов тодорхой илэрхийлж буйг онцлон хариу цохилт хийж байв.

Доналд Трамп энэ мэтээр хувийн амьдрал руу нь чиглэсэн дайралт өөрийн дэмжигчдийг алдахгүй гэсэн нэг оролдлого байлаа. Учир нь хамгийн сүүлд авсан мэдээлээр 10 гаруй сенатч, 12 гишүүн, гурван мужийн захирагч түүний эсрэг нэгдсэн бөгөөд Доналд Трампыг Цагаан ордны төлөө өрсөлдөөнөөс нэрээ татахыг шаардаж, түүний оронд Дэд Ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлсэн Майк Пенсийг өрсөлдүүлэх

хэрэгтэй гэх уриалга ч намынхны дунд эрчимжжээ. Тэдний дунд Доналд Трамптай Ерөнхийлөгчийн сунгаанд өрсөлдөж байгаад, тулаанаа орхиж түүнийг дэмжихээр болсон Митт Ромни, Жей Буш, Тед Круз нарын улстөрчид ч байгаа гэнэ. Мөн Бүгд найрамдах намын гишүүн, Төрийн нарийн бичгийн дарга асан Кондолиза Райс тэрбумтан эрийг өрсөлдөөнөөс гарахыг уриалсан байдаг ч, Доналд Трамп олны шүүмжлэлийн үл тоон, өрсөлдөөнөөс гарах бодолгүй байгаагаа мэдэгдсэн. Хоёр нэр дэвшигчийн ширүүн маргаан мэтгэлцээний төгсгөлд нэгэн үзэгч тэднийг өрсөлдөгчийнхөө ядаж ганц сайхан талыг хэлэхгүй юу гэхэд Хиллари Клинтон үзэгчдийн суудалд суусан Доналд Трампын хүүхдүүдийг дурьдаад, чадварлаг, аавдаа үнэнч гэсэн бол Хиллари Клинтоны тухайд “Тэр өдий хүртэлх хугацаанд өрсөлдөөнийг орхиогүй. Дайчин эмэгтэй. Энэ бол маш сайн чанар” гэж үнэлсэн юм. Энэ удаагийн мэтгэлцээнд нэр дэвшигчийн хэн ялсан тухай албан ёсны санал асуулгын дунд гараагүй ч Хиллари ялсан гэж зарим ажиглагч үзэж байна. Гэхдээ Доналд Трамп ч төсөөлснөөс сайн байлаа гэж дүгнэж байна.

АНУ, БНСУ-ын цэргийн хамтарсан сургуулилт эхэллээ

Умард Солонгос дахин цөмийн туршилт хийж магадгүй байгаатай холбоотойгоор АНУ, БНСУ-ын зэвсэгт хүчин өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, Солонгосын хойгийн өмнөд болон баруун эрэгт цэргийн хамтарсан сургуулилт явуулж эхэллээ. Зургаа хоног үргэлжлэх уг сургуулилт өнөөдөр Шар тэнгис дэх Чезжу арал орчмын усанд эхэлсэн байна.

Уг сургуулилтын зорилго нь Умард Солонгост үзүүлж буй цэргийн дарамт шахалтыг нэмэгдүүлэх явдал юм. АНУ-ын зэвсэгт хүчин Японы Ёкосукэ хот дахь боомт руугаа нисэх онгоц тээвэрлэгч “USS Ronald Reagan” хөлөг онгоцыг илгээхээр төлөвлөжээ. Харин Умард Солонгос уг сургуулилтыг эрс эсэргүүцэж мэдэгдэл гаргасан байна. Өнгөрсөн лувраг гаргагч Умард Солонгосын Гадаад хэргийн яам мэдэгдэл хийхдээ, АНУ-ыг аймшигт ирээдүй хүлээж байна гэсэн юм. БНАСАУ-ын Хөдөлмөрийн нам үүснэ байгуулагдсаны 71 жилийн ой өнөөдөр тохнож байгаа бөгөөд уг тэмдэглэлт өдрийг тохиолдуулан тус улс балисттик нуужин туршиж болзошгүй байгаад олон улс түгшиж байна.

Колумбийн Ерөнхийлөгч шагналасаа буяны үйлсэд зориулна

Колумбийн Ерөнхийлөгч Хуан Мануэл Сантос хагас зуун жилийн турш үргэлжилсэн иргэний дайныг эцэслэхийн тулд сөргөлдөгч талтайгаа энхийн хэлэлцээр байгуулахад хүчин чармагт гаргаж ирсэн. Гэвч тус улсын ард иргэд энхийн хэлэлцээр байгуулах эсэх талаархи санал асуулгад “Үгүй” гэсэн хариултыг өгснөөр хэрэгжих боломжгүй болсон юм. Тэгвэл түүний энэ мэт хичээл зүтгэлийг үнэлж, энэ оны Нобелийн энхтайвны шагналд тодорхойлсон байдаг. Тэгвэл Ерөнхийлөгч Сантос Нобелийн шагналыг нь дагалдан ирэх найман сая швейцарь кроньг иргэний дайны хохирогчдын төлөөх буяны үйлсэд хандивлана гэдгээ мэдэгдлээ. 2002 онд болсон дэлбэрэлтэд өргөж амиа алдсан иргэдийн дурсгалыг хүндэтгэх ёслолын үйл ажиллагаанд Засгийн газрын гишүүд болон эхнэр хүүхдийнхээ хамтаар оролцох үедээ тэрбээр энэ талаар мэдэгдсэн байна. Нийтдээ 52 жилийн турш үргэлжилсэн Колумбийн иргэний дайнд 260 гаруй мянган хүн нас барсан бөгөөд 45 мянган хүн одоо ч ор сураггүй болсонд тооцогддог ажээ. Түүнчлэн, долоон сая орчим хүн орон гэрээ орхин дүрвэсэн байна. Нобелийн энхтайвны шагналыг гардуулах ёслолын үйл ажиллагаа Норвегийн Осло хотноо ирэх арванхоёрдугаар сарын 10-нд зохион байгуулагдана.

МЭДЭЭЛЭЛ

ПАКИСТАНД БЭЛТГЭГДСЭН ТЕРРОРИСТУУД ЭНЭТХЭГТ ХАЛДЛАГА ҮЙЛДЭЖ БАЙНА ГЭВ

Б.ДАВАА

Пакистан, Энэтхэг улсын хиллэдэг Кашмирын бүс нутагт хэд хэдэн удаа террорист халдлага болж, олон цэргийн алба хаагч амь үрэгдсэн талаар манай хэвлэл мэдээллийн агентлагууд дамжуулж байсан юм. Тэгвэл үүсээд буй нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилгоор Бүгд найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Суреш Бабу өчигдөр хэвлэлийн хурал зарлалаа. Хэвлэлийн хурлын эхэнд тэрбээр Кашмирын бүс нутгийн талаархи мэдээ мэдээлэл бэлтгэн уншигчид, үзэгчдэд хүргэж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудад талархал илэрхийлэхэд сүүлийн долоо хоногт бий болсон нөхцөл байдлын талаар танилцуулав. Элчин сайд Суреш Бабу “Энэтхэгийн Жамму Кашмирт сүүлийн хэдэн долоо хоногийн турш сөргөлдөөний нөхцөл байдал үүсээд буй. Террористууд Кашмирын хяналтын бүсийг давж, нэвтрэх гэсэн оролдлогууд нь зөвхөн энэ он гарсаар 20 орчим бүртгэгдснийг Энэтхэгийн арми амжилттай илрүүлэн устгасан. Энэ мэт халдлага, оролдлогууд энгийн иргэдийн амьдралд аюул заналхийлэл учруулах болсон билээ. Энэ жил болсон гол гол үйл явдлыг нэрлэхэд, 2016 оны нэгдүгээр сард нисэх онгоцны буудалд томоохон халдлага болсон бол долдугаар сард ч мөн террорист халдлага зохион байгуулагдсан.

Эдгээр бүх халдлагын явцад энгийн иргэд амь насаа алдах, гэмтэж бэртэх тохиолдол удаа дараа гарч байна. Хамгийн сүүлийн жишээ дурьдахад, өнгөрсөн сарын 11, 18-нд Пуунч, Урид тус тус террорист халдлага болсныг та бүхэн мэдэж байгаа.

Тус халдлагыг Пакистаны хяналтад байдаг Кашмирын бүсэд бэлтгэгдэж, дадлага сургуулилт хийсэн алан хядагчид үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд энэ үеэр 19 цэргийн алба хаагч амиа алдсан. Есдүгээр сарын 18-ны халдлагын дараа хоёр ч халдлага болсон. Сүүлийн хоёр халдлагыг Энэтхэгийн цэргийн хүчин даруй зогсоон устгасан байгаа. Гэвч Пакистаны тал өөрсдийн газар шороо, нутаг дэвсгэрийг Энэтхэгийн эсрэг террористид ашиглахыг үл зөвшөөрч, манай нутаг дэвсгэр рүү нэвтрэх, террорист үйл ажиллагаа явуулахгүй байна гэсэн 2004 оны нэгдүгээр сард гаргасан амлалтаа бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа нь сөргөлдөөнийг улам дэвсгэж байна. Урид болсон халдлагын дараа Энэтхэгийн арми халдлагын эсрэг чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан. Ингэхдээ Пакистаны хяналтад байгаа алан хядагчдын тусиц цэг рүү гэнэтийн халдлагыг есдүгээр сарын 28-29-нд шилжих шөнө гүйцэтгэж, долоон цэгт довтолж амжилттай устгасан байна. Энэтхэгийн армийн цэргийн ажиллагааны ерөнхий захирал Ранбир Сингх есдүгээр сарын 30-ны өглөө хэвлэлийн хурал зохион байгуулж энэ үеэр терроризмын эсрэг үйл ажиллагааны талаар дурьдсан” гэсэн юм.

Элчин сайдын яамныхан хэвлэлийнхэнд Энэтхэгийн цэргийн ажиллагааны Ерөнхий захирал Ранбир Сингхын хэвлэлийн хурлын үеэр хэлсэн үгийг бүрэн эхээр нь англи, монгол хэл дээр хэвлэн сэтгүүлчдэд өгсөн. Уг бичигт дурьдагдсанаар, он гарсаар хяналтын цэгийн дагуу Энэтхэг рүү нэвтрэхийг завдсан 20 орчим оролдлогын үеэр баривчлагдсан алан хядагчид Пакистаны газар нутаг, түүний хяналтад байдаг Кашмирын бүс нутагт тэднийг бэлтгэж, цэргийн

дадлага сургуулилт хийдэг болохыг хүлээн зөвшөөрчээ. Түүнчлэн тэд биедээ Пакистаны талын тэмдэглэл бүхий байршил тогтоогчийг авч явж байсан аж. Улмаар Энэтхэгийн цэргийн алба хаагчид Пакистаны террористуудыг байцаах, үнэнийг нь хүлээлгэж баталгаажуулахын

үймээн самуунаас урьдчилан сэргийлж, ард иргэдийнхээ амьдралд аюул занал учруулахаас сэргийлэхийн тулд Пакистаны нутаг дэвсгэр дэх алан хядагчдын түшиц цэг рүү хариу цохилт өгсөн гэдгээ мэдэгджээ.

Түүнчлэн, зарим олон улс судлаач, орчуулагчид Кашмирын

амлалтаа хүндэтгэж, тус улсын арми бидэнтэй хамтран ажиллаж, терроризмын аюул заналыг арилгахыг хүсч байна. Энэтхэгийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд ямар хүч шаардагдана тэр бүхнийг зориулах болно” гэдгийг хэвлэлийн хурлын үеэр онцолж байлаа. Тиймээс ч, дэлхийн өнцөг



тулд Консулын туслацааг санал болгож, Ури, Пуунчд болсон сөргөлдөөний үеэр амиа алдсан алан хядагчдын хурууны хээ, ДНК-ын шилжилгээг авч Пакистанчуудад судалгаа шинжилгээ явуулахад нь өгөхөөр бэлтгэсэн байна. Мөн үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор Энэтхэгийн арми өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж буй гэнэ.

Тэд мөн террористуудыг нутагтаа нэвтрүүлэхгүй байх,

бүс нутгийн байдал хурцадсаныг онцолж байсан юм. Тэгвэл эл асуудалд Энэтхэг улсаас Монгол Улсад суух Элчин сайд Суреш Бабу “Энэтхэг улс нөхцөл байдлыг хүндрүүлэх бодолгүй байна. Бид энэ асуудалд хорш Пакистан улстай хамтран ажиллахыг хүсч байна. Пакистаны тал 2004 оны нэгдүгээр сарын өөрийн газар шороо, нутаг дэвсгэрийг Энэтхэгийн эсрэг террористид ашиглахыг үл зөвшөөрнө гэсэн

булан бүр дэх тус улстай найрсаг харилцаатай орнууддаа хандан Кашмирын бүс нутагт өрнөж буй сөргөлдөөнийг дэлгэрэнгүй мэдээлж, нийт хүмүүсийн анхаарлыг энэхүү үйл явдалд хандуулахад анхаарч ажиллаж буйгаа мэдэгдлээ. Кашмирын бүс нутагт сүүлийн 25 жилийн турш үргэлжилж буй терроризмын аюулаас үүдэлтэйгээр нийтдээ мянга гаруй хүн нас барсан байна.

ШУУРХАЙ МЭДЭЭ

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ ОН ДУУСТАЛ ХЭРЭГЖИНЭ

Н.БАТЗАЯА

Гэр бул, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Алтансүхэс зарим зүйлийг тодрууллаа.

-Бага насны хүүхдүүдэд цэцэрлэгийн өмнөх боловсрол олгоход хүүхэд харах үйлчилгээ чухал үүрэг гүйцэтгэсэн. СӨБ эзэмшиж чадахгүй, гэртээ цоожтой үлддэг олон хүүхэд энэ үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон. Энэ хууль хэрэгжиж эхэлснээр хэчнээн хүүхдийн асуудлыг шийдсэн бэ?

-Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нийт 290262 хүүхэд байгаагаас 225388 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байна. Цэцэрлэгийн ачааллыг бууруулах зорилгоор "Хүүхэд харах үйлчилгээний тухай" хуулийг гаргаж яаран сандран гаргаж мөрдүүлсэн. Угтаа бол хүүхэд харагч нарыг сургах, хүүхэд харах байрыг стандартын дагуу байгуулах зэрэг олон асуудлыг энд орхигдуулсан. 2016 оны есдүгээр сарын байдлаар тус үйлчилгээнд 6353 хүүхэд хамрагдаж, 1305 хүүхэд харагч ажиллаад байна.

-Хууль эрхзүйн талаас учир дутагдалтай зүйлс байгаа гэсэн үг үү?

-Энэ хууль нь нэршил талаасаа л учир дутагдалтай байгаа юм. Хүүхэд харах үйлчилгээ. Уг нь бол хүүхдийг харах бус хөгжүүлж, боловсруулж, сургах ёстой биз дээ. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага энэ ажлыг хийдэг. Би дээр хэлсэн 2016 он байдлаар тус үйлчилгээнд 6353 хүүхэд хамрагдаж, 1305 хүүхэд харагч ажиллаж байна.

Энэ нь нэг хүнд дунджаар 4-5 хүүхэд ногдож байна гэсэн үг. ЕБС, СӨБ-ын системд тавигдаж байгаа шаардлага ямар байдаг билээ. Гэтэл энэ хүүхэд харах үйлчилгээнд ажиллаж байгаа хүмүүс ямар шаардлагад нийцэж байгаа бол, энд тавигдаж байгаа хяналт шалгалт байна уу. Энэ нь цаанаа эрсдэл дагуулж буй байдал харагдаж байна. Ер нь бол хүүхдийн хүмүүжлийн асуудал ч орхигдож байгаа юм. Нэгдүгээр асуудал асарч байгаа юм шиг хэрнээ нөгөө гараараа сөнөөж байж таарахгүй.

учраас энэ аргагүй байдлыг харгалзан үзээд Засгийн газраас он дуустал Хүүхэд харах үйлчилгээг явуулахаар ажиллаж байна. Гэхдээ нэг ч хүүхдийг нэмж бүртгэхгүй, яг одоо явуулж буй үйл ажиллагааг нь он дуустал хэрэгжүүлнэ.

-Тэгэхээр шинэ Засгийн газар илүү боломжит хувилбарыг бодож олсон гэсэн үг үү?

-Энэ бодлогын зөрүүтэй байдлыг арилгах үүднээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Цалинтай ээж" хөтөлбөрийг ярилцаж байна. Энэ хөтөлбөр нь хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүртэл хөтөлбөрийг хоол тэжээлийн дутагдалгүй, эсэн мэнд өсөн торних боломжийг олгох юм. Энэ нь хүнийг хүн болгох концепци талаасаа "Цалинтай ээж" гэдэг хөтөлбөр маань илүү оновчтой гэж үзэж байна.

Мөн "Байгууллагын цэцэрлэг" хөтөлбөрийг дэмжиж байна. Энэ хүрээнд манай байгууллага ч оноос өмнө байгууллагын цэцэрлэгээ нээхээр ажиллаж байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ХАНИАД ТОМУУНААС СЭРГИЙЛ


Хүйтэн сэрүүний улирал эхлэхтэй зэрэгцээ ханиад томууны дэгдэлт ихэсдэг. Тэр дундаа бага насны хүүхэд энэ насны өвчнөөр өвчлөх нь ихэсдэг байна. Тиймээс бага насны хүүхдийг олон нийтийн газраар авч явахгүй байх, явч явах шаардлага гарсан тохиолдол дулаан хувцаслаж байхыг ХӨСҮТ-өөс анхаарууллаа. Мөн тус өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд хооллохын өмнө гараа сайн савандаж угаах, аяга, халбага, гар нүүрийн алчуурыг солихгүй байх, эрдэс витаминээр баялаг хоол хүнс хэрэглэж, халуун бүлээн зүйл ойр ойрхон уух хэрэгтэй байна.

2500 иргэн нийгмийн хэв журмыг сахиулж байна

Нийслэлийн иргэд сайн дураар нийгмийн хэв журмыг сахин хамгаалахад оролцохоор болжээ. Тодруулбал, нийслэлийн нутаг дэвсгэр, гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн орчинд оршин суух идэвхтэй 2500 иргэнийг сонгон сар бүр тодорхой мөнгөн урамшил олгож, хөдөлмөр аюулгүй байдлын таних тэмдгээр ханган ажиллуулахаар болсон аж. Энэхүү ажил өчигдөр эхэллээ. Сайн дурын иргэд

гэмт хэрэг ихээр гардаг цэг, цагуудад тухайн орчинг хяналтад авч эргүүлд гарах гэнэ. Ингэхдээ цагдаагийн алба хаагчидтай хамтран ажиллах ажээ. Уг ажил хэрэгжсэнээр цагдаагийн байгууллага, иргэд хоорондын уялдаа холбоо сайжирч, гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдсэн гэмт хэргийг богино хугацаанд илрүүлж, гэмт санаа бодол тээгчийн сэтгэл санаанд нөлөөлж, өөрчлөлт оруулах зэргээр эерэг үр дүн гарах юм байна.

PHOTO NEWS



Спортын гэрэл зурагчин Ч.Ганбатын "Риогийн олимп миний дуранд" гэрэл зургийн үзэсгэлэн "Blue Moon" арт галерейд өнгөрсөн атралтын өдрүүдэд гарлаа. Бразилийн Рио Де Жанейро хотноо болсон Зуны XXXI олимпын наадмыг сурвалжилсан Монголын жудо бөхийн холбооны дэд ерөнхийлөгч, Монголын спортын сэтгүүлчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Ч.Ганбат өөрийн буулгасан 64 бүтээлээ үзэсгэлэнд дэлгэжээ. Тэрбээр "Рио-2016" наадмын 64 онцгой агшинг танилцуулахыг зорьсон аж.

Өршөөлөөр суллагдсан этгээд дахин гэмт хэрэг үйлджээ

Автомат тоглоомын газарт галт зэвсэгтэй этгээд халдсан байна. Тодруулбал, Сүхбаатар дүүргийн нутагт байрлах автомат тоглоомын газарт нэгэн этгээд буу гарган иргэдийг сүрдүүлж, хоёр иргэнийг хутгалж танхайрсан хэрэг энэ сарын 9-10-нд шилжих шөнө гарчээ. Энэ талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн мэргэжилтэн Ё.Лхагвасүрэн хэлэхдээ "2016 оны аравдугаар сарын 10-ны шөнөний 00.00 цагийн үед "Сүхбаатар дүүргийн нэгдүгээр хорооллын ... орон сууцанд зодоон болоод байна" гэх мэдээлэл цагдаагийн байгууллагад ирсэн. Мэдээллийн дагуу шалгахад тус байранд

байсан нэр бүхий 10 иргэн рүү А, Б гэгч этгээдүүд хэсэг бүлэг хүмүүсийн хамт зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашиглан биед нь халдаж, онц их хэмжээний мөнгө дээрэмдсэн хэрэг гарсан байна.

Тухайн гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн газар, Сүхбаатар дүүргийн нэгдүгээр хэлтсийн алба хаагчидтай хамтран шалгаж гэмт хэргийг үйлдэхэд "толгойлж" оролцсон гэх А, Б нарыг дайчлан баривчилж, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж байна. Харин А, Б нартай хамт байсан этгээдүүдийг одоогоор эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байна. Түүнчлэн гэмт хэргийн

улмаас алга болсон мөнгө, эд зүйлийг эрэн хайх ажиллагаа явагдаж байна" гэв. Халдлагад өртсөн иргэдийн тухайд 25-30 насны залуус аж. Тэдний хоёр нь халдлагын үеэр хүндэтгэр зэргийн гэмтэл авсан бөгөөд ГССҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа юм байна. Харин гэмт хэргийг "толгойлсон" А гэгч 2016 оны долдугаар сард Өршөөлийн тухай хуулиар суллагдсан нэгэн гэнэ. Мөн Б нь шүүхээс тэнсэн харгалзах ялтай байхдаа уг хэргийг үйлдсэн талаар баттай эх сурвалж мэдээллээ. Тэд хэргийн газраас онц их хэмжээний мөнгө бусдын эд зүйл дээрэмдсэн гэх мэдээлэл байна.

"Guys" хамтлагийн Х.Бат-Унралд хоёр жилийн тэнсэн ял оноожээ

"Guys" хамтлагийн дуучин Х.Бат-Унралыг өнгөрсөн дөрөвдүгээр сард Замын-Үүдийн гаалиар их хэмжээний хар тамхи оруулах гэж байгаад баригдсан билээ. Тэгвэл түүний хэргийг өчигдөр Сонгинохайрхан, Баянгол, Хануул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хянан хэлэлцлээ. Х.Бат-Унралд Эрүүгийн хуулийн 192.1-д заасны дагуу ял төлөвлөсөн. Эрүүгийн

хуулийн тус зүйл ангид Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөрсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэгдэж байна. Харин шүүх Замын-

Үүдийн гаалиар их хэмжээний хар тамхи оруулах гэж байгаад баригдсан хэрэгт буруутгагдсан Х.Бат-Унралд хоёр жилийн ял оноож, тэнсэн харгалзах шийдвэр гаргажээ. Анхан шатны шүүхээс Х.Бат-Унралыг гэм буруутай гэж үзэн хоёр жил хорих ял оногдуулж, мөн хугацаагаар тэнсэн харгалзахаар боллоо.

Адуунд яваад сураггүй болсон малчны цогцсыг олов

Морь барьж ирэхээр гэрээсээ гарсан иргэн сураггүй болжээ. Тодруулбал, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Бумбат багийн малчин Б энэ сарын 7-ны өглөө адуунаасаа морь барьж ирэхээр гэрээсээ гараад сураггүй болсон байна. Түүнийг алга болсон өдөр ар гэрийнхэн нь түүнийг хайсаар үдэш болоход олоогүй тул сумынхаа ЗДТГ-ын даргад мэдэгджээ. Ар гэрийнхнийх нь мэдээллийн дагуу орон нутгийн 11 иргэн хоёр машинд хуваагдан эрэлд гарч, маргааш өдөр нь малчин Б-гийн цогцсыг 14.30 цагийн үед Хүйсийн хар овоо гэдэг газраас олж, сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгчид шилжүүлэн өгсөн байна. Одоогийн байдлаар амиа алдсан шалтгаан нь тодорхойгүй байгаа аж.

Галт тэрэг машинтай мөргөлдөж, хүний амь эрсдэв

Дархан-Уул аймгийн "Энхтал" зөрлөгийн 97 дугаар км-т төмөр замын гарам дээр ачааны галт тэрэг автомашинтай мөргөлдөж, хүний амь эрсдсэн харамсалтай хэрэг гарчээ. Тодруулбал, энэ сарын 8-ны өдрийн 13:30 цагийн үед ачааны 3603 дугаар галт тэрэг төмөр замын гарам дээр "Hyundai Porter" автомашинтай мөргөлдсөн байна. Ослын улмаас Дархан-Уул аймаг Орхон сумын харьяа "Hyundai Porter" автомашины жолооч 29 настай Г нас барж, хамт явсан зорчигч 23 настай залуу гэмтжээ. Уг хэргийг Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт шалгаж байна.



ТЕГ-Т
ЗАСВАР
ХИЙЖ
БАЙСАН
АЖИЛЧИД
ГАЛ
АЛДЖЭЭ

Татварын ерөнхий газарт өнгөрсөн баасан гарагт 12:27 цагт гал гарсан байна. Галыг НОБ-ын 10 дугаар ангийн аврагчид шуурхай ажиллан унтраажээ. Тэгвэл галын эх үүсвэрийг тогтоожээ. Тодруулбал, ТЕГ-ын үүдний дэвэрийг засч байсан нэгэн компанийн ажилчинд хар цаас нааж байгаад гал алдаж, 2-5 давхрын гаднах хөөсөн пасад шатсан байна. Уг хэргийг Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс шалгаж байгаа аж.

Оддын ЦАТ



Орчуулсан Б.ДАВААХҮҮ

Дэлхийн хөлбөмбөгийн од Лионель Мессигийн "World soccer" сэтгүүлд өгсөн ярилцлагыг сонирхуулж байна. Тэрбээр энэ ярилцлагыг 2013 оны нэгдүгээр сарын 1-нд өгч байжээ. Эдүгээ дэлхий дахинаа гайхагдсан шилдэг тамирчин тухайн үед өөрийнхөө талаар болон Барселона багийнхаа талаар хэрхэн ярьж байсныг энэ удаагийн "Оддын цаг" булангаараа орчуулан хүргэж байна.

Лионель Месси:

Бага байхаас л хөл минь бөмбөгтэй холбогдсон

-Хамгийн анх хөлбөмбөг тоглож байсан дурсамжаасаа хуваалцаач?

-Би бүр багаасаа хөршийнхөө хүүхдүүдтэй хөлбөмбөг тоглодог байсан. Магадгүй гурав, дөрвөн настай л байсан болов уу. Тиймээс бага байхаас л миний хөл, бөмбөг хоёр холбогдсон гэж би боддог.

-Магадгүй тэр үед дүрмийн бус арга барилаар тоглох, өшиглүүлэх тохиолдол гарч байсан байх даа?

-Дүрмийн дагуу тоглодог байсан. Хүүхдүүд намайг өшиглөхч вий гэдгээ санаа зовж байгаагүй юм байна.

-Барселона багт орсон эхний хэдэн долоо хоног, эсвэл сарын хугацаа таны хувьд үгээр илэрхийлэхийн аргагүй баярт үйл явдал, эсвэл хүндэн цаг мөчийн аль нь байв?

-Аль аль нь давхацсан. Барселона хотод амьдарч, шинэ шинэ зүйлсийг сурч мэдэж буйдаа баяртай байсан. Гэхдээ тэр хүртэл хамтдаа тоглож байсан багийнхнаасаа хол байх нь хэцүү байв. Барселонад ирснээр дахиад л шинэ баг, шинэ найзтай болох ёстой болсон. Түүнчлэн хамгийн анхныхаа тоглолтод гэмтэл болоод бичиг баримтын

тодорхой асуудлын улмаас тоглож чадаагүй юм. Ер нь эхлэл хэцүү байсан.

-Хөлбөмбөгийн спорт дахь шүтээн чинь хэн бэ?

-Пабло Аймарыг шүтдэг.

-Хөлбөмбөгийн спортоор хичээллэх, тоглоход намхан тамирчдад ямар нэг бэрхшээл тулгардаг уу?

-Үгүй, биеийн өндөртэй холбоотой ямар ч бэрхшээл гарч байгаагүй. Би сургуульд байхдаа ч тэр, одоогийн багтаа ч хамгийн намхан нь.

-Та одоогийн тоглолтын хэв маягаа Барселонад орсныхоо

дараа олж авсан уу?

-Миний тоглолтын хэв маяг огт өөрчлөгдөөгүй. Өмнө нь ямар байсан одоо ч тэр л хэвээрээ байгаа. Би хэзээ ч тодорхой хэв маягийг бий болгон хөгжүүлэхийг оролдож байсангүй. Бага байхаасаа л өөрийнхөөрөө тоглож ирсэн. Гэхдээ мэдээж багийнхаа залуусаас олон зүйлийг сурч, мэдсэнээ үгүйсгэхгүй. Бид өөр өөрсдийнхөөрөө л ажиллаж байна. Бөмбөгтэйгөө хэрхэн харилцах, тактикаа боловсруулах тал дээр маш их ажиллаж байгаа. Аргентинд байхдаа энэ мэт бэлтгэлийг хийж байгаагүй. Харин

энд ирснээр өмнө нь байснаасаа илүү их гүйж, илүү их дасгал сургуулийг хийх болсон.

-Багтаа орсны дараа анхны лигийн тоглолтоо хийх гэж байхад паспортын асуудал гарсан гэсэн?

-Надад тулгарсан хүнд мөчүүдийн нэг байсан. Гэхдээ азаар хурдан хугацаанд асуудлаа шийдвэрлэж чадсан. Би тэр үед талбайд гарахыг туйлын их хүсч байлаа. Надад багтайгаа анхны тоглолтоо хийх боломж тэр үед байсан. Гэвч, багийнхан зөвшөөрөөгүй. Намайг яагаад тоглуулаагүйг би ойлгодоггүй.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 9
Шөнө -4

Нөгөөдөр
Өдөр 12
Шөнө -2

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Хоёр хар мэнгэтэй Улаан бар өдөр. Ангараг гараг

Үс засуулбал: Эрч хүч ихэснэ

Наран ургах, шингэх: 07:10 - 18:23



Өдрийн өнгө: Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сорог муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэлтнийг шийтгэх, харсаал, жатхыг буцаах, атьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балеадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, болбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, тогой, хонь, нохойболтой. Хол газар яваар одогсод баруун урагш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч ихэснэ.

ДУУЛГАХ СОНИН

"Приусын босс" нэрээ сольж магадгүй

"Милл" кино компани "Микроны босс" кино хийж, үзэгчдийн хүртээл болгосон билээ. Тэгвэл энэхүү киноны үргэлжлэл болгож, "Приусын босс" уран сайхны киног хийж байгаа ажээ. Одоогоор киноны зураг авалт эхэлсэн бөгөөд яваандаа нэрээ сольж

магадгүй юм байна. Киноны гол дүрд жүжигчин С.Батзориг, "Мөрөөдлийн театр"-ын жүжигчин Д.Батгомөр, режисер Жи, жүжигчин О.Долгор, УДЭТ-ын жүжигчин Ц.Цэрэнболд нар тоглож байгаа аж. Кино 2017 оны эхээр үзэгчдэд хүрэх юм байна.

Бидэнд тохиолдсон



Р. Энхчимэг

Заримдаа их сонин сонин юм үзэх юм даа. Их сургуульд нэг ч удаа ярьж үзээгүй залуу нэг удаа над руу мессэж бичив. Чи ч онц сурдаг байсан гэсэн үү, хаана ажиллаж байна гээд л. Тэгж элдэв юм бичиж байснаа хоёулаа ярьж байла л даа гэж байна. Тэгснээ ч мобикомын дугаар барьдаг уу гэлээ. Би ч тийм л гэв. Гэтэл өөдөөс мобигийн 1000 нэгж явуулаач, хоёулаа гоё ярыг гэдэг юм даа. Ха ха ха. Өөр ч тайван даа.

Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж буй долоон кино театрийн дэлгэцнээ гарч буй кинонуудаас хамгийн олон үзэгчтэй байгаа киноны талаархи мэдээллийг хүргэж байна. Монголын уран сайхны кинонуудаас есдүгээр сарын 28-нд нээлтээ хийсэн "Цагаан хадаг" кино одоог хүртэл үзэгчдийн тоогоор тэргүүлж байгаа бөгөөд түүний араас өнгөрсөн амралтын өдөр нээлтээ хийсэн "Итгэл" болон "Талзуу



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үзэгчийн тоогоор "ЦАГААН ХАДАГ" кино тэргүүлж байна

зугаалга", "Одод болохын хүслэн" зэрэг кинонууд удаалж байна. Харин гадаад кинонуудаас өвөрмөц содон бүтээлээр кино сонирхогчдын мэлмийг гэрэлтүүлж, оюун санааг нь сэргээж байдаг домогт найруулагч Тим Бартоны 2016 оны цоо шинэ дэлгэцийн бүтээл "Хатагтай Перегриний" үзэгчдийн тоогоор тэргүүлж байна. Удаах байранд адал явдалт,

триалер төрлийн киног маш чадварлаг бүтээдэг Марк Уолбергийн тоглосон "Deerwater Horizon" кино үзэгчдийн тоогоор тэргүүлсэн хэвээр байгаа аж. Холливудын киноноос эдгээр хоёр бүтээлийг Монголын үзэгчид хамгийн ихээр шимтэн үзэж байгаа бол "Зайдасны үдэшлэг", "Өрөө тас" зэрэг кинонууд удаалж байна.



2016.10.11-НИЙ ҮЗВЭРИЙН ХУВААРЬ

 19:00	 11:20 13:10 14:35vip 17:00 19:00 21:00 22:50	 10:30 12:20 14:20	 13:10 17:30 21:00vip 23:10vip	 11:00 12:30vip 15:20 19:30 21:10
 15:00 19:20vip 21:35 23:20	 11:30 14:10 16:10 18:40 21:40 23:20	 11:30 14:10 16:10 18:40 21:40 23:20	 11:30 14:10 16:10 18:40 21:40 23:20	 11:30 14:10 16:10 18:40 21:40 23:20